

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл		
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх (ТСР/MON/3701)		
2	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБ ХХААБ		
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААБ, ХХААХҮЯ		
		Хэрэгжих нийт хугацаа: 1 жил 5 сар		
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)		
		<p>Зорилт 1: Одоогийн шүлхийтэй тэмцэх арга хэмжээнд үнэлгээ хийж, эрсдэлд суурилсан шүлхийтэй тэмцэх стратеги боловсруулах,</p> <p>Зорилт 2: Сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчдийг чадавхжуулах, шаардлагатай багаж хэрэгслээр хангах,</p> <p>Зорилт 3: Шүлхий өвчнөөс сэрэмжлүүлэх материал боловсруулж олон нийтэд хүргэх,</p> <p>Зорилт 4: Шүлхий өвчний үед хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх,</p> <p>Зорилт 5: Малын халдварт өвчний тархалтад шилжилт хөдөлгөөний үзүүлэх нөлөөг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох.</p>		
5	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Төслийн болон удирдлагын зардалд 2019 оны жилийн эцсийн байдлаар 219,073 ам.доллар зарцуулж 73% хувийн биелэлттэйгээр санхүүжилтийг зарцуулсан байна.	
		Үүнд:	Төсөв (2019 он)	Гүйцэтгэл
	Багц 1	300,000	219,073	73%
	Нийт	300,000	219,073	73%
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ		
	1-р зорилтын хүрээнд: Шүлхийтэй тэмцэх арга хэмжээнд үнэлгээ хийж, эрсдэлд суурилсан шүлхийтэй тэмцэх стратеги боловсруулах. Хүрэх үр дүн 1: Шүлхийтэй тэмцэх үйл ажиллагаа болон стратегид үнэлгээ хийх, Стандарт ажиллагааны зааврыг эцэслэн зүүн бүс дэх тархалтыг бууруулж төв, баруун бүсэд халдвар тархахаас сэргийлэх.	<ul style="list-style-type: none"> Одоогийн шүлхийтэй тэмцэх арга хэмжээнд үнэлгээ хийж зөвлөмж боловсруулан Мал эмнэлгийн ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. Шүлхийтэй тэмцэх дунд хугацааны (2020-2023) стратегийн төслийг боловсруулан мал эмнэлгийн ерөнхий газарт хүлээлгэн өгч, ХХААХҮ-ийн сайдаар батлуулахаар ажиллаж байна. Шүлхий өвчин Монгол улсад тархах эрсдэлт хүчин зүйлсийн үнэлгээ хийсэн. Шүлхий өвчний үед дэгдэлтийн судалгааг хэрхэн хийх талаарх Стандарт ажиллагааны зааврын төслийг боловсруулсан. 		

	<p>2-р зорилтын хүрээнд: Сумын мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйчдийг чадавхижуулах, шаардлагатай багаж хэрэгсэлээр хангах</p> <p>Хүрэх үр дүн 2: Мал эмнэлгийн шүлхийтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чадавхи сайжирсан байна.</p> <p>Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • 2019 онд 15 аймгийн 309 сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчдийг “Дэгдэлтийн судалгаа, био-хамгаалал” сургалтад хамруулсан. • 80.000 орчим ам.долларын өртөг бүхий мал эмнэлгийн багаж хэрэгслийг (шүлхийн түргэн тест, халдвар хамгааллын хувцас, малаас дээж авах багаж, халдваргүйжүүлэх бодис гэх мэт) орон нутгийн мал эмнэлгийн байгууллагуудад хүргүүлэв. • Шүлхий өвчний дэгдэлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний үзүүлэх сургалтыг 2019 оны 10 дугаар сард зохион байгуулж Өмнөговь, Төв, Өвөрхангай, Дундговь аймгийн нийт 75 малын эмч нар оролцлоо. • Шүлхий өвчний үед малаас хэрхэн дээж авах, илгээх талаар 5 төрлийн видео хичээл бэлтгэж, МЭЕГ-ын Facebook хуудсаар дамжуулан малын эмч нарт хүргэв.
	<p>3-р зорилтын хүрээнд: Шүлхий өвчнөөс сэрэмжлүүлэх материал боловсруулж олон нийтэд хүргэх</p> <p>Хүрэх үр дүн 3: Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн мэдлэг, ойлголт сайжирна.</p>	<ul style="list-style-type: none"> • Монголын Олон Нийтийн Радио Телевизтэй хамтран мал эмнэлгийн салбарт хийгдэж байгаа онцлох үйл ажиллагаануудын талаар нэвтрүүлэг бэлтгэн, 2019 оны туршид сар бүр 2 удаа буюу нийт 24 удаа нэвтрүүлэв. Мөн бэлтгэсэн нэвтрүүлгүүдийг МЭЕГ-ын Facebook хуудсанд байршуулсан. • Малчдад зориулсан шүлхийгээс сэрэмжлүүлэх 5 төрлийн анимейшн бэлтгэж, Малчин ТВ-гээр нийт 282 удаагийн цацалтаар олон нийтэд хүргэв.
	<p>4-р зорилтын хүрээнд: Шүлхий өвчний үед хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх</p> <p>Хүрэх үр дүн 4: Одоогийн шүлхийтэй тэмцэх үйл ажиллагаа сайжирч, төв болон баруун бүсэд халдвар тархахаас сэргийлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • Шүлхий өвчин гарсан үед хорио цээрийн үйл ажиллагаанд хяналт тавих зориулалттай өндөр хүчин чадал бүхий 2 ширхэг Дроныг (нисдэг камер) МЭЕГ-т хүлээлгэн өгөв. • 2018-2019 онд хийгдсэн шүлхийн халдвар илрүүлэх тандалт болон дархлаажуулалтын дараах тандалтын үр дүнг хэлэлцэх уулзалт зохион байгуулав. Мал эмнэлгийн ерөнхий газар, 21 аймгийн мал эмнэлгийн газрын дарга нар, улсын мал эмнэлгийн төв лабораторийн холбогдох албаны хүмүүс оролцсон.
	<p>5-р зорилтын хүрээнд: Малын халдварт өвчний тархалтад шилжилт хөдөлгөөний үзүүлэх нөлөөг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох</p> <p>Хүрэх үр дүн 5: Малын шилжилт хөдөлгөөний хяналт, дархлаажуулалтын судалгаа, шүлхийтэй тэмцэх чиглэлээр хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох үйл ажиллагаа сайжирна.</p>	<ul style="list-style-type: none"> • Малын шилжилт хөдөлгөөн нь халдварт өвчний тархалтад хэрхэн нөлөөлдөг болохыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох зорилгоор Архангай аймгийн Хотонт сумын 6 малчны хонинд GPS хүзүүвч суурилуулав. Уг судалгааны ажил нь 1 жилийн хугацаанд үргэлжлэх бөгөөд үр дүн нь 2020 оны 8 сард гарна.

7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололттой тал: 1. Төслийг боловсруулахдаа МЭЕГ-ын холбогдох мэргэжилтнүүдээс ямар үйл ажиллагаануудыг уг төслийн хүрээнд хэрэгжүүлэх нь үр дүнтэй талаар тэдний санал авч тусгасан нь төсөл амжилттай хэрэгжих үндэс болсон.</p> <p>Дутагдалтай тал: 1. Төслийн хүрээнд боловсруулсан Шүлхийтэй тэмцэх стратегийн төслийг 2019 оны 8 дугаар сард МЭЕГ-т хүлээлгэн өгсөн боловч ХХААХҮ-ийн сайдаар батлуулах ажил удаашралтай байна. 2. Төслийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиглэлд МЭЕГ анхаарал хандуулах шаардлагатай. Тухайлбал: Шүлхийтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөө гэх мэт 3. Төслийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажлууд он дамжин хийгдэж байгаа нь үнэлгээнд сөргөөр нөлөөлж байна. Төлөвлөгөөний 5.1, 5.2</p>						
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хамтран хэрэгжүүлсэн оролцогчдоос тайлан авч, гарсан үр дүнг нэгтгэн тайлагнах шаардлагатай.						
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		86.6%	5	95.0	95.7	92.5	100.0	50.0
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)					Нэгдсэн үнэлгээ		

НҮБ-ЫН ХХААБ-ЫН “МОНГОЛ УЛСЫН ТӨВ БОЛОН БАРУУН БҮС НУТАГТ ШҮЛХИЙ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХЭД ЯАРАЛТАЙ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТСР/MON/3701” ТЕХНИК ТУСЛАЛЦААНЫ ТӨСӨЛ

Төслийн хэрэгжилт, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт (төгрөгөөр)

№	Төслийн нэр	Гэрээний мэдээлэл			Сунгалтын мэдээлэл			Нийт хэрэгжүүлэх хугацаа (жилээр)	Хэрэгжүүлж байгаа хугацаа (жилээр)	Төсөл хэрэгжих хугацааны ашиглалт (%)	Гэрээ сунгасан тайлбар (сунгалт бүрээр)
		Гэрээ байгуулсан огноо	Гэрээг хэрэгжүүлэх хугацаа	Гэрээ дуусах хугацаа	Хэдэн удаа сунгасан	Сунгасан хугацаа (сараар)	Гэрээ дуусах эцсийн хугацаа				
1	Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх ТСР/MON/3701	2019.01.01	11 сар	2019.10.30	1	5 сар	2020.04.30	1 жил 5 сар	1 жил 5 сар	73%	

Төслийн хэрэгжилт, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт (төгрөгөөр)

№	Төслийн нэр	Гэрээний үндсэн валют	Нийт санхүүжилт			Үүнээс: 2019 оны санхүүгийн жилд		Ашиглалтын хувь /%/	
			Батлагдсан	Ашиглалт	Ашиглалт USD	Батлагдсан	Ашиглалт	Нийт хөрөнгийн	Тухайн санхүүгийн жилийн
1	Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх ТСР/MON/3701	Ам.доллар	300,000	219,073	219,073	225,000	219,073	73%	97%

Төслийн хэрэгжилт, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт (төгрөгөөр)

№	Төслийн нэр	Гэрээний үндсэн валют	2019 оны зарцуулалт		2019 оны төсвийн жил		Үүнээс:			
			Дүн (мян.нэгж. үндсэн валют)	Дүн (мян.нэгж.ам доллар)	Төсөв	Гүйцэтгэл	ТХН-ийн үйл ажиллагааны зардал	Дотоод зөвлөх үйлчилгээ	Гадаад зөвлөх үйлчилгээ	Хөрөнгө оруулалт
1	Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх ТСР/MON/3701	ам.доллар	219,073	219,073	225,000	219,073	3,733.04	13,186.07	20,090.00	18,187.72

Төслийн төлөвлөсөн ажлын биелэлт

№	Төслийн нэр	Бүрэлдэхүүн хэсгийн тоо	Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийх ажлын тоо	Үүнээс: Биелэлт хангалтгүй	Бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтийн хувь	Тайлбар
1	Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх TCP/MON/3701	1	21	0	92%	Төслийн үйл ажиллагаанууд төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.

А. Ажлын байрны судалгаа

№	Төслийн нэр	Төслийн ажилтны тоо*	Төслийн хүрээнд шинээр бий болсон ажлын байрны тоо		Шинээр бий болох 2020 онд
			Нийт /өссөн дүнгээр/	2019 оны байдлаар	
1	Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх TCP/MON/3701	1	1	1	0

Б. Сургалтын судалгаа

№	Төслийн нэр	Сургалтын тоо		Сургалтад хамрагдсан хүний тоо		Сургалтад хамрагдсан байгууллагын нэрс
		Нийт	Үүнээс: 2019 онд	Нийт	Үүнээс: 2019 онд	
1	Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх TCP/MON/3701	21	15	359	309	Сумдын мал эмнэлгийн тасаг